



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/566

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "е", 29.2, Төсвийн тухай хуулийн 14.2.3, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2008 оны ҮХ/06дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 2019 оны ээлжит бус Х хуралдааны 01 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөр нийгмийн зөвшлийн 2019-2020 оны 3 талт хамтын хэлэлцээрийн хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээнд зарцуулах 20,0 сая /Хорин сая/ төгрөгийн зардлыг хавсралтаар баталж, Засаг дарга дансны "Нийгмийн түншлэлийн гурван талт хэлэлцээр"-ийн зардлаас зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Нармандах/-д зөвшөөрсүгэй.

2. Арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Нарантуяа/, аймгийн Ажил олгогч эздийн холбооны нарийн бичгийн дарга /Б.Базардамбуу/, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга /Ц.Ганболд/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД